



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/УБЧ

Зуунмод

Газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5.1, Зуунмод сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2.1.5-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 1-р баг, Цэлмэг хотхон, Рашааны гудамж 101А тоотод газар нэмж өмчилхөөр хүсэлт ирүүлсэн иргэн Дорж овогтой Чулуунсүрэн /НЮ45031476/-д гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 332 м2 газрыг 1,328,000 /1м2=4000/ төгрөгөөр худалдаж өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгч иргэн Д.Чулуунсүрэнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлэхийг даалгасугай.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Улсын бүртгэлийн хэлтэс /Н.Энхбат/-д дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 01320